



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/20/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 261628 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Аудитор: О.Баярмаа
Утас: 261740 Цахим хаяг: bayarmaao@audit.gov.mn
Аудитор: М.Лхагвасүрэн
Утас: 261740 Цахим хаяг: lkhagvasurenm@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1.Аудитын гэрчилгээ	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа	17
4.2 Албан шаардлага	17
4.3 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА С.МАГНАЙСҮРЭН ТАНАА

2022.02.24 № 07/306
танай _____-ны № _____-г

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Барилга, хот байгуулалтын яамны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Барилга, хот байгуулалтын яамны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	606,873,209.55	23,868,672.67
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,373,400.00	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	2,373,400.00	-
31110	Төгрөг	2,373,400.00	-
33	АВЛАГА	543,787,950.00	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	543,787,950.00	-
34	УРЬДЧИЛГАА	34,781,064.55	1,687,667.67
34600	Урьдчилж гарсан зардал	34,781,064.55	1,687,667.67
35	БАРАА МАТЕРИАЛ	25,930,795.00	22,181,005.00
354	Хангамжийн материал	25,930,795.00	22,181,005.00
35410	Бичиг хэргийн материал	3,101,925.00	1,376,425.00
35420	Аж ахуйн материал	951,240.00	-
35470	Бусад хангамжийн материал	21,877,630.00	20,804,580.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	332,632,755.63	333,563,803.83
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	332,632,755.63	333,563,803.83
392	Биет хөрөнгө	325,156,298.52	322,231,796.75
39203	Авто-тээврийн хэрэгсэл	512,955,798.00	417,279,798.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(342,224,131.29)	(215,863,661.13)
39205	Машин тоног төхөөрөмж	398,858,717.59	435,644,182.97
39206	Хуримтлагдсан элэгдэл	(291,814,582.30)	(354,266,805.73)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	234,857,851.07	241,757,851.07
39208	Хуримтлагдсан элэгдэл	(197,251,434.39)	(209,650,128.11)
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,179,675.00	17,179,675.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(7,405,595.16)	(9,849,115.32)
393	Биет бус хөрөнгө	7,476,457.11	11,332,007.08
39301	Программ хангамж	1,920,810.00	8,757,010.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,920,810.00)	(3,629,859.99)
39303	Бусад биет бус хөрөнгө	25,100,800.00	25,100,800.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(17,624,342.89)	(18,895,942.93)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	939,505,965.18	357,432,476.50
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	2,117,984.19
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	2,117,984.19
413	Өглөг	-	2,117,984.19
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	2,117,984.19
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	939,505,965.18	355,314,492.31
51	Засгийн газрын хувь оролцоо	939,505,965.18	355,314,492.31
511	Засгийн газрын оруулсан капитал	324,390,884.93	324,390,884.93
51101	Өмч: - төрийн	324,390,884.93	324,390,884.93
512	Хуримтлагдсан үр дүн	615,115,080.25	30,923,607.38
51210	Өмнөх үеийн үр дүн	(146,825,299.84)	614,976,112.91
51220	Тайлант үеийн үр дүн	761,940,380.09	(584,052,505.53)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	939,505,965.18	357,432,476.50

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	10,360,895,596.58	129,063,254,018.92
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	285,539,056.58	120,214,658,041.26
120	Нийтлэг татварын бус орлого	285,539,056.58	120,214,658,041.26
120009	Бусад орлого	19,585,000.00	120,132,227,339.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	265,954,056.58	82,430,702.26
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,075,356,540.00	8,848,595,977.66
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,881,471,800.00	7,918,499,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,881,471,800.00	7,918,499,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,193,884,740.00	930,096,377.66
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	26,946,000.00	-
131103	ЗГНХ, ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	412,738,740.00	579,059,160.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,754,200,000.00	351,037,217.66
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,591,844,869.60	124,647,306,524.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,591,844,869.60	124,647,306,524.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,453,535,636.77	3,928,265,133.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,867,485,556.71	1,978,263,033.00
210101	Үндсэн цалин	1,867,485,556.71	1,978,263,033.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	235,003,876.00	258,818,136.04
210201	Тэтгэврийн даатгал	161,753,170.00	180,690,216.82
210202	Тэтгэмжийн даатгал	19,029,786.00	20,101,830.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,995,348.00	15,842,903.92
210204	Ажилгүйдлийн даатгал	3,565,962.00	3,834,834.51
210205	Эрүүл мэндийн даатгал	35,659,610.00	38,348,350.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,086,010.00	10,371,500.00
210304	Байрны түрээс	18,086,010.00	10,371,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	79,016,345.00	82,780,032.66
210401	Бичиг хэрэг	19,410,058.00	18,629,110.00
210402	Тээвэр, шатахуун	16,132,200.00	16,254,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,118,700.00	18,549,582.66
210404	Ном, хэвлэл	16,085,100.00	14,614,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,270,287.00	14,732,140.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,232,150.00	985,800.00

210604	Урсгал засвар	1,232,150.00	985,800.00
2107	Томилолт, зочны зардал	13,372,900.00	7,631,900.00
210702	Дотоод албан томилолт	13,372,900.00	7,631,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,741,942,367.00	900,517,176.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,730,009,835.00	891,671,990.00
210803	Даатгалын үйлчилгээ	7,664,500.00	7,655,590.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	558,552.00	488,596.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,665,480.00	602,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	497,396,432.06	688,897,556.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	426,392,640.00	598,101,802.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	71,003,792.06	90,795,754.06
212	ТАТААС	-	120,116,802,339.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	-	120,116,802,339.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	-	120,116,802,339.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	138,309,232.83	602,239,051.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	86,770,652.00	250,945,900.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	23,605,249.00	19,803,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	190,200,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	63,165,403.00	40,942,900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	51,538,580.83	255,934.03
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,538,580.83	255,934.03
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	351,037,217.66
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	351,037,217.66
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	5,769,050,726.98	4,415,947,494.47
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,007,110,346.89	5,000,000,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	7,110,346.89	-
230001	Эргэж төлөгдөх зээл	5,000,000,000.00	5,000,000,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(5,007,110,346.89)	(5,000,000,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН	761,940,380.09	(584,052,505.53)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	324,390,884.93	-	(146,825,299.84)	177,565,585.09
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	324,390,884.93	-	(146,825,299.84)	177,565,585.09
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	761,940,380.09	761,940,380.09
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	324,390,884.93	-	615,115,080.25	939,505,965.18
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(138,967.34)	(138,967.34)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	324,390,884.93	-	614,976,112.91	939,366,997.84
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(584,052,505.53)	(584,052,505.53)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	324,390,884.93	-	30,923,607.38	355,314,492.31

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	10,100,956,890.00	129,524,611,266.66
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,958,400.00	120,132,227,339.00
120	Нийтлэг татварын бус орлого	21,958,400.00	120,132,227,339.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,078,998,490.00	9,392,383,927.66
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,881,471,800.00	7,918,499,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,881,471,800.00	7,918,499,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,197,526,690.00	1,473,884,327.66
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив	30,587,950.00	-
131102	ЗГНХ, ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	412,738,740.00	579,059,160.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,754,200,000.00	543,787,950.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	351,037,217.66
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,079,988,790.00	124,517,688,566.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,079,988,790.00	124,517,688,566.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,397,891,607.17	3,798,647,175.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,855,577,514.17	1,940,165,355.31
210101	Үндсэн цалин	1,453,437,914.17	1,204,138,857.25
210102	Нэмэгдэл	350,721,400.00	684,608,298.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	51,418,200.00	51,418,199.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	266,513,500.00	261,923,400.00
210201	Тэтгэврийн даатгал	187,546,600.00	184,316,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	19,741,700.00	19,401,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,793,400.00	15,521,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,948,300.00	3,880,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	39,483,500.00	38,803,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,086,010.00	10,371,500.00
210304	Байрны түрээс	18,086,010.00	10,371,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	73,588,746.00	66,439,965.86
210401	Бичиг хэрэг	15,762,528.00	14,074,322.00
210402	Тээвэр, шатахуун	16,132,200.00	13,712,400.00
210403	Шуудан, холбоо, интернэт	14,118,700.00	11,138,443.86
210404	Ном, хэвлэл	16,085,100.00	15,425,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,490,218.00	12,089,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,232,150.00	985,800.00
210604	Урсгал засвар	1,232,150.00	985,800.00
2107	Томилолт, зочны зардал	13,372,900.00	8,090,400.00
210702	Дотоод албан томилолт	13,372,900.00	8,090,400.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,743,128,147.00	915,060,862.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,731,195,595.00	903,637,776.80
210803	Даатгалын үйлчилгээ	7,664,500.00	7,655,590.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	558,552.00	488,596.00
210805	Тээврийн хэрэгслийн онош	44,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,665,500.00	3,179,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	426,392,640.00	595,609,892.00
210901	Бараа үйлчилгээний бусад	426,392,640.00	595,609,892.00
212	ТАТААС	-	120,116,802,339.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	-	120,116,802,339.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	-	120,116,802,339.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	682,097,182.83	602,239,051.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	86,770,652.00	250,945,900.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	23,605,249.00	19,803,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	190,200,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	63,165,403.00	40,942,900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	51,538,580.83	255,934.03
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,538,580.83	255,934.03
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	543,787,950.00	351,037,217.66
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	543,787,950.00	351,037,217.66
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	5,020,968,100.00	5,006,922,700.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	18,594,700.00	9,296,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,594,700.00	9,296,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	18,594,700.00	9,296,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	18,594,700.00	9,296,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(18,594,700.00)	(9,296,100.00)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	5,000,000,000.00	5,000,000,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	5,000,000,000.00	5,000,000,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(5,000,000,000.00)	(5,000,000,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2,373,400.00	(2,373,400.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,373,400.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,373,400.00	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,918,499,600.00	7,918,243,665.97	255,934.03	100.0
УРСГАЛ ЗАРДАЛ	2,918,499,600.00	2,918,243,665.97	255,934.03	99.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,667,354,100.00	2,667,297,765.97	56,334.03	100.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,940,173,500.00	1,940,165,355.31	8,144.69	100.0
Үндсэн цалин	1,243,191,300.00	1,204,138,857.25	39,052,442.75	96.8
Нэмэгдэл	645,564,000.00	684,608,298.16	(39,044,298.16)	106.0
Унаа хоолны хөнгөлөлт	51,418,200.00	51,418,199.90	0.10	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	261,923,400.00	261,923,400.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	184,316,500.00	184,316,500.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	19,401,700.00	19,401,700.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	15,521,400.00	15,521,400.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	3,880,300.00	3,880,300.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	38,803,500.00	38,803,500.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,371,500.00	10,371,500.00	-	100.0
Байрны түрээс	10,371,500.00	10,371,500.00	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	51,017,400.00	51,014,965.86	2,434.14	100.0
Бичиг хэрэг	14,096,500.00	14,074,322.00	22,178.00	99.8
Тээвэр, шатахуун	13,712,400.00	13,712,400.00	-	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,118,700.00	11,138,443.86	(19,743.86)	100.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,089,800.00	12,089,800.00	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	985,800.00	985,800.00	-	100.0
Урсгал засвар	985,800.00	985,800.00	-	100.0
Томилолт, зочны зардал	8,090,400.00	8,090,400.00	-	100.0
Дотоод албан томилолт	8,090,400.00	8,090,400.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	380,614,700.00	380,569,012.80	45,687.20	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	369,182,700.00	369,145,926.80	36,773.20	99.9
Даатгалын үйлчилгээ	7,664,500.00	7,655,590.00	8,910.00	99.9
Тээврийн хэрэгслийн татвар	488,600.00	488,596.00	4.00	100.0
Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000.00	99,000.00	-	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,179,900.00	3,179,900.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	14,177,400.00	14,177,332.00	68.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	14,177,400.00	14,177,332.00	68.00	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	251,145,500.00	250,945,900.00	199,600.00	99.9
Бусад урсгал шилжүүлэг	251,145,500.00	250,945,900.00	199,600.00	99.9
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	20,002,600.00	19,803,000.00	199,600.00	99.0
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	190,200,000.00	190,200,000.00	-	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	40,942,900.00	40,942,900.00	-	100.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	5,000,000,000.00	5,000,000,000.00	-	100.0
Эргэж төлөгдөх зээл	5,000,000,000.00	5,000,000,000.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,918,499,600.00	7,918,499,600.00	-	100.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,918,499,600.00	7,918,499,600.00	-	100.0
Улсын төсвөөс санхүүжих	7,918,499,600.00	7,918,499,600.00	-	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-		

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-		
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
АЖИЛЛАГСАДЫН ТОО	78	78	-	100.0
Удирдах ажилтан	11	15	-4	136.3
Гүйцэтгэх ажилтан	61	63	-2	103.3
Гэрээт ажилтан	6	-	6	-

2.6 Аудит хийсэн Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгөн хөрөнгийн 2021 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл		
ОРЛОГЫН ДҮН	-	1,473,884,327.66
ЗГНХ, ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	579,059,160.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	543,787,950.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	351,037,217.66
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН		1,473,884,327.66
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,122,847,110.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	543,787,950.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	579,059,160.00
ТАТААС БА УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	351,037,217.66
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	351,037,217.66
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	351,037,217.66
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Барилга, хот байгуулалтын яамны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр өөрийн эзэмшлийн хөрөнгийг шилжүүлж байх талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 14-нөөс 2022 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын аудитор О.Баярмаа, М.Лхагвасүрэн нар гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Эрдэнэзул, аудитын менежер Д.Энхдалай, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

Барилга, хот байгуулалтын яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 3/340 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Барилга, хот байгуулалтын яамны эрхэм зорилго нь хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүй, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, орон сууц, нийтийн аж ахуйн бодлогын үр нөлөөг дээшлүүлэх замаар хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны стратегийн зорилтуудыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүй, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, орон сууц, нийтийн аж ахуйн салбарын хууль тогтоомжийн төсөл, бодлого, хөтөлбөрийн хувилбар боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, салбарын норм, нормативын баримт бичгийн тогтолцоог бүрдүүлэх, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх;
- Тус яамны чиг үүрэгтэй холбогдон гарсан хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт, шалгалт, хяналт-шинжилгээ, аудит хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах;
- Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, санхүү, эдийн засгийн төлөвлөлтийн үр дүнг дээшлүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн, нийтийн аж ахуй, орон сууцны, инженерийн дэд бүтцийн, хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүйн салбаруудын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын 2021 оны төлөвлөгөөнд Барилга, хот байгуулалтын яамны аппаратын санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийхээр батлагдсан боловч ахлах нягтлан бодогчийг дотоод аудитад шилжүүлэн томилсон тул ашиг сонирхлын зөрчил үүссэнээс шалтгаалан аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Барилга, хот байгуулалтын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгосон. Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоосон.

Сонгосон суурь үзүүлэлтээс тооцож төлөвлөлтийн материаллаг байдлыг 95,918.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Барилга, хот байгуулалтын яамны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 582,073.5 мянган төгрөгөөр буюу 61.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, хуримтлагдсан үр дүнгийн дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,373.4	-	(2,373.4)
Авлага	543,788.0	-	(543,788.0)
Урьдчилгаа	34,781.1	1,687.7	(33,093.4)
Бараа материал	25,930.8	22,181.0	(3,749.8)
Үндсэн хөрөнгө	332,632.8	333,563.8	931.0
Нийт хөрөнгийн дүн	939,506.0	357,432.5	(582,073.5)
Өглөг	-	2,118.0	(2,118.0)
Засгийн газрын хувь оролцоо	939,506.0	355,314.5	584,191.5
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	939,506.0	357,432.5	582,073.5

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлагын дансны үлдэгдэл 543,788.0 мянган төгрөгөөр буурсан нь Ногоон нуур 1008 айлын орон сууц төслийн газар чөлөөлөлтийн төлбөрийн олгогдоогүй үлдэгдлийг өмнөх оны эцэст улсын төсөвт төвлөрүүлснийг Сангийн яамнаас буцаан олгосон;
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 584,191.5 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны авлагын үлдэгдлийг барагдуулан, газар чөлөөлөлтийн төлбөрийг олгосонтой холбоотой тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагчийн 2021 оны үйл ажиллагаанд 2,918,499.6 мянга, Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх зарим хөтөлбөрийн хүрээнд Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-д олгох дамжуулан зээлдүүлэх зээлийн эх үүсвэрт 5,000,000.0 мянга, нийт 7,918,499.6 мянган төгрөгийн төсвийг төлөвлөж хүргүүлснийг хэвээр баталсан байна.

Төсвийн тодотголоор санхүүжилтийн эх үүсвэр болон урсгал зардлыг нийт 88,590.0 мянган төгрөгөөр хасаж баталсан байна. Үүнд: Цалингийн зардлын 34,000.0 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн 4,590.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн 50,000.0 мянган төгрөг тус тус эзэлж байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс 7,918,499.6 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос урсгал үйл ажиллагаанд 2,918,243.7 мянган төгрөгийг зарцуулж, Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-д олгох 5,000,000.0 мянган төгрөгийн дамжуулан зээлдүүлэх зээлийн төлбөрт шилжүүлэн, зарцуулаагүй 255.9 мянган төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 99.9 хувьтай байгаа нь ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшууллын зардлыг 199.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт-2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөг/	
	Код	Нэр			Зөрүү	Биелэлт
1	71509	Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр	7,918,499.6	7,918,243.7	255.9	99.99
1.1	80101	Үйл ажиллагааны урсгал зардал	2,918,499.6	2,918,243.7	255.9	99.99
1.2	83117	Дамжуулан зээлдүүлэх зээл	5,000,000.0	5,000,000.0	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зарим хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж Засгийн газрын нөөц сангаас Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын ашиглалтын өмнөх захиргааны 343,900.0 мянга, Аэросити төслийн 180,000.0 мянга, Майдар хот төслийн 55,159.1 мянга, Дээд шатны төсвийн захирагчийн

төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс Ногоон нуур 1008 айлын орон сууц төслийн газар чөлөөлөлтийн төлбөрт 543,788.0 мянга, нэмэлт орлогоор “Орон сууцны хороолол, дэд бүтэц төсөл”-ийн дамжуулан зээлийн эргэн төлөлтийн 351,037.2 мянга, нийт 1,473,884.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Ногоон нуур 1008 айлын орон сууц төслийн газар чөлөөлөлтийн төлбөрийн, Аэросити болон Майдар хот төслийн, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын ашиглалтын өмнөх захиргааны санхүүжилтийг тус тус бүрэн олгож, Орон сууцны хороолол, дэд бүтэц төслийн дамжуулан зээлийн төлбөрийн 351,037.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд БХБЯ-ны түр дансаар дамжуулан Засгийн газрын 2021 оны 207 дугаар тогтоолын дагуу “Цэвэр, бохир усны төлбөрийг төрөөс хариуцах”-аар шийдвэрлэсний дагуу ус хангамж, ариутгах, татуургын ашиглалт үйлчилгээг тасралтгүй найдвартай хангах үүргийг хүлээсэн тусгай зөвшөөрөл бүхий эзэмшигчээс ирүүлсэн цэвэр бохир усны үйлчилгээний гүйцэтгэлийг Хот, суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс хянан баталгаажуулснаар 120,116,802.3 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөр, 2 арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж, зарцуулсан төсвийн гүйцэтгэл 99.9 хувийн биелэлттэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх зээлийн санхүүжилтийн эх үүсвэр 5,000,000.0 мянган төгрөгийг Төсвийн шууд захирагчийн төсөвт төлөвлөж, батлуулснаас зээлийн эргэн төлөлтөд тавих хяналт сулрах, зээлийн эрсдэл үүсэж болзошгүй тул цаашид анхаарах шаардлагатай.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш орлогын 28,065.6 мянга, зарлагын 33,565.6 мянга, нийт 61,631.2 мянган төгрөгийн 9 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулах, зөрчлийг гаргахгүй байх зөвлөмж өгөх.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Барилга, хот байгуулалтын яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмыг мөрдөж, зөрчлийг давтан гаргахгүй байх" албан шаардлагыг хэрэгжүүлж, зөрчлийг давтан гаргаагүй байна. Мөн 1 албан шаардлага болон зөвлөмжийг тус тус 90.0 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

/мянган

төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	1	48,800.0	1	48,800	-	-	90.0
Зөвлөмж	2	6,400.0	2	6,400.0	-	-	90.0
Нийт дүн	3	55,200.0	3	55,200.0	-	-	-

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын ашиглалтын өмнөх захиргаанд олгосон нэмэлт санхүүжилтийн зарцуулалтын үр дүнг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 66,162.4 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 1,002.1 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 3,529.1 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 61,631.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчлийн 65,160.3 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 95,918.4 мянган төгрөгөөс хэтрээгүй тул “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Шатахууны тайлан дахь дүнгээс Петростар ХХК-д шилжүүлсэн шатахууны дүн 690.1 мянган төгрөгөөр илүү, ерөнхий журналын дүнгээс 312.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;

4.2 Албан шаардлага

Тайлант оны эцэст ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд 1,687.7 мянган төгрөгийг илүү шилжүүлэн авлага үүсгэсэн, тус авлагыг урьдчилж гарсан зардалд бүртгэсэн, мөн хувь хүний орлогын албан татварт 1,841.5 мянган төгрөгийг дутуу шилжүүлэн өглөг үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. *Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал*

1.1 Илрүүлэлт:

Тус яамны үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 0453УБҮ улсын дугаартай "Hyunday sonata-7" маркийн автомашиныг 2021 оны 12 сараас Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-т ашиглуулж байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т "Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эд хөрөнгийг худалдах, шилжүүлэхэд энэ хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагын зөвшөөрөл авна" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Өөрийн эзэмшлийн автомашиныг ТӨБЗГ-ын тогтоолыг үндэслэн шилжүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Зөвлөмж			
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	Тоо	дүн		
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1	БХБЯ	АХГ-2022/20/НА-СТА-ТШЗ	Авлага, өглөгийн талаар	Тайлант оны эцэст ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд 1,687.7 мянган төгрөгийг илүү шилжүүлэн авлага үүсгэсэн, мөн тус авлагыг урьдчилж гарсан зардалд бүртгэсэн, мөн хувь хүний орлогын албан татварт 1,841.5 мянган төгрөгийг дутуу шилжүүлэн өглөг үүсгэсэн байна.	1	3,529.1						1	3,529.1			
2	БХБЯ	АХГ-2022/20/НА-СТА-ТШЗ	Үндсэн хөрөнгийн талаар	Тус яамны үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй "Hyundai sonata-7" маркийн автомашиныг 2021 оны 12 сараас Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-т ашиглуулж байна.	1	-								-	-	
3	БХБЯ	АХГ-2022/20/НА-СТА-ТШЗ	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар	Шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш орлогын 28,065.6 мянга, зарлагын 33,565.6 мянга, нийт 61,631.2 мянган төгрөгийн 9 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	61,631.2								1	61,631.2	
4	БХБЯ	АХГ-2022/20/НА-СТА-ТШЗ	Залруулах	Шатахууны тайлан дахь дүнгээс Петростар ХХК-д шилжүүлсэн шатахууны дүн 690.1 мянган төгрөгөөр илүү, ерөнхий журналын дүнгээс 312.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	1,002.1	1	1,002.1								
Дүн					4	66,162.4	1	1,002.1	-	-	1	3,529.1	1	61,631.2		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 93/АД170066
АХГ-2022/20/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу гүйцэтгэсэн Барилга, хот байгуулалтын яамны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эцэст ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд 1,687,667.67 төгрөгийг илүү шилжүүлэн авлага үүсгэсэн, тус авлагыг урьдчилж гарсан зардалд бүртгэсэн, мөн хувь хүний орлогын албан татварт 1,841,489.74 төгрөгийг дутуу шилжүүлэн өглөг үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлага, өр төлбөрийн 3,529,157.41 төгрөгийн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, ахлах нягтлан бодогч П.Билгүүнтөр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЭНХДАЛАЙ

О.БАЯРМАА



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264250

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-13.Docx

001081622

